



КЛУБИЙН ТУХАЙ

Хүнсний инженерчлэл хөтөлбөрийн дэргэдэх Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний технологи мэргэжлийн “Зөв, зохистой хооллолт”-ын Оюутны клубт энэхүү мэргэжлийн нийт оюутнууд хамрагддаг бөгөөд уг клубийн үйл ажиллагааг 2012 оноос энэ мэргэжлийн ахлах багш, Док (Ph.D) С.Сэржмядаг хариуцан ажиллаж байна. “Зөв, зохистой хооллолт” оюутны клубийн үйл ажиллагаа нь зохистой хооллолтын мэдлэг олгох, оюутнуудад өргөн хэрэглээний хүнсний түүхий эдээр богино хугацаанд өөртөө зориулж шим тэжээллэг хоол хийж сургахад оршиж байна

КЛУБИЙН ЗОРИЛГО: Эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэх

ЗОРИЛТ. Мэргэжил сурталчлах болон тус салбарын оюутнуудыг идэвхжүүлэх

КЛУБИЙН ЖУРАМ

- Цаг баримтлах;
- Багаар ажиллах;

- Төлөвлөгөөний дагуу ажиллах;
- Бүтээлч сэтгэлгээтэй байх;

КЛУБД ЭЛСЭН ОРОХ

Хүнсний инженерчлэл хөтөлбөрийн Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний технологи мэргэжлийн ангийн оюутнууд хамрагдана.

КЛУБИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Өглөөний хоолны ач холбогдол
- Эрүүл амьдралын хэв маяг болох хооллолт ба зөвлөмж
- Аливаа өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх чадамж
- Санхүүгийн хэмнэлт

ЗОХИОН БАЙГУУЛАЛТ. Оюутан залуусын зохистой хооллолтын хүрээнд мэдлэг олгох зорилгоор цаашид хэвшүүлэх үүднээс мэргэжлийн багштайгаа хамтран ажилладаг.

КЛУБИЙН АМЖИЛТ

- Монгол Улсын Гавьяат багш, Академич С.Батманхийн нэрэмжит ШУТИС-ийн “Эрдэмийн XVIII чуулган”-ны шилдэг бүтээлийн уралдаанд “БАЯЖУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН” Сэдэвт бүтээл “ГУТГААР БАЙР” эзэлсэн. 2018 он
- УТС-ийн “ШИЛДЭГ КЛУБ-2017”
- ШУТИС-ийн “ШИЛДЭГ КЛУБ-2017”





- “Монголын инновацийн 7 хоног-2018” арга хэмжээг 2018 оны 05 дугаар сарын 07-13-ны өдрүүдэд үндэсний хэмжээнд, олон улсын нийтлэг жишгийн дагуу зохион байгуулах ажилд идэвхтэй оролцож

“ИННОВАЦИЙН ҮЗЭСГЭЛЭН-2018”, UB Innovation center “Шинэ бүтээлээрээ оролцов”



ШУТИС-ийн “Эрдмийн XVI чуулган”-ны Шилдэг бүтээлийн уралдаанд “Баяжуулсан кекс, жигнэмэгийн боловсруулалт, оюутны өглөөний хоол” сэдвээр ДЭД БАЙР эзэлсэн /2016 оны 4 сарын 28/

2014-2015 оны хичээлийн жилд:

ШУТИС-ийн 4 дотуур байранд лекц (9-р сарын 30, 10 сарын 3,6), 3,4-р байранд сургалт семинар (10-р сарын 10) Дотуур байранд амьдардаг оюутнуудад хэрхэн зөв зохистой, эрүүл хоол хүнс хэрэглэх, түүхий эд бүтээгдэхүүн худалдан авах, боловсруулах, хэрэглэх, хадгалах талаар сургалт семинар явагдлаа. Сургалтанд нийт давхардсан тоогоор 410 оюутан залуус хамрагдсан. Уг сургалтыг нийт 12 оюутан удирдан зохион байгуулсан бөгөөд эдгээр оюутнуудад ШУТИС-ийн ОХҮА-наас “Багшийн туслах оюутан” сертификат олгосон болно.



2015-2016 оны хичээлийн жилд:

“Зохистой хооллолт” сургалт нь дотуур байранд амьдарч буй оюутнуудад зохистой хооллолтын мэдлэг, дадал олгох зорилгоор 10 сарын 22нд “Зохистой хооллолт”, 10 сарын 26 нд “**Гурил бүтээгдэхүүн, талх, жигнэмэг хийх аргачлал, түүний ач холбогдол**”, 10 сарын 28 нд “**Дайвар бүтээгдэхүүн, түүний ангилал, ач тус, хоол боловсруулах технологи ажиллагаа**” лекц, сургалт явуулсан. Энэ лекцэнд давхардсан тоогоор нийт 377 оюутан хамрагдсан. Мөн лекцийнхээ дагуу 10 дугаар сарын 31, 11 дүгээр сарын 1-ний өдөр хэрхэн хялбар аргаар хоол хийх технологи ажиллагааг зааж, зөвлөмж өгсөн. Сургалтыг 8 оюутан, багшийн хамт зохион байгуулсан.



2016-2017 хичээлийн жилд:

Оюутанд зөв хооллох зан төлвийг хэвшүүлэх, зохистой хооллолтын талаар мэдлэг олгох, хүнсээ зөв сонгон хоол хийж сурах мэдлэгийн хүрээнд халдварын бус өвчлөлийн гаралтыг оюутан залуусын дунд бууруулах үйл ажиллагааг зохион байгуулсан. Үүнд:

- Инженер, технологийн дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэсний 55 жилийн ойг угтсан ШУТИС-ийн “Эрдмийн XVI чуулган”-ны Шилдэг бүтээлийн уралдаанд “Баяжуулсан кекс, жигнэмэгийн боловсруулалт, оюутны өглөөний хоол” сэдвээр ДЭД БАЙР эзэлсэн /2016 оны 4 сарын 28/
- Сүхбаатар дүүргийн үзэсгэлэн-худалдаанд өөрсдийн бүтээлээр оролцсон. Иргэдийн сэтгэл ханамж өндөр байсан төдийгүй клубын цаашдын үйл ажиллагааг дэмжсэн сайшаалтай өдөрлөг болж өнгөрсөн.
- 2016 оны 05 сард БСШУЯ-наас зохион байгуулсан “Оюутны санаачилгын төсөл”-ийн хүрээнд оюутны клубын үйл ажиллагааг идэвхжүүлэх чиглэлээр “Зохистой

хооллолт”-ын төслийг Профессор, Доктор (Ph.D) С.Дэлгэрмаа, Ахлах багш (Ph.D) С.Сэржмядаг нарын санаачлагаар боловсруулж хэлэлцүүлсэн.

- ШУТИС-ийн шинэ оюутанд хэрэгжүүлж буй “Багш оюутны 7 хоног” хөтөлбөрийн хүрээнд “Эрүүл зохистой хооллолт” сургалт болон хоолны жишиг бичлэгийг хүргэсэн https://www.youtube.com/watch?v=Z6-PhbxU508&list=UUFTv-sSkFkccp_prrrx0acQ&index=7 (2016 оны 11 сарын 18).

2017-2018 оны хичээлийн жилд:

Эрүүл, зөв зохистой хооллолтын клубын 25 гишүүн ШУТИС-ийн оюутны байруудаар 4 хуваагдан нийт 234 оюутанд Эрүүл зөв зохистой хооллолтын сургалт зөвлөгөөг зохион байгуулав.

“**Зохистой хооллолтын ач тус**” нээлтэй лекцыг 2017 оны 12 сарын 06 өдөр зохион байгуулав.

Зохиистой хооллолт лекц нь:

- Эрүүл хооллолт гэж юу вэ?
- Хэрхэн зөв эрүүл амьдрах вэ?
- Өглөөний цайны ач тус
- Зохиистой эрүүл хүнс.
- Зөв дадал.

Зэрэг сэдвийн хүрээнд ШУТИС-ийн 1,2 курсын 50 орчим оюутанд лекц уншив.

Лекцийн үеэр өглөөний цайндаа хэрэглэж болохуйц жишиг 5 нэр төрлийн хоолны үзэсгэлэн гаргаж амталгаа хийлгэлээ. Мэргэжилийн оюутнуудын дунд “Cook show-21” тэмцээнийг “21-р зууны зөв зохистой хооллолт ба гэрэлт ирээдүй” сэдвийн доор хорин нэг дэх удаагаа 2017 оны 11-р сарын 11 өдөр зохион байгуулав.

- Монгол Улсын Гавьяат багш, Академич С.Батманхийн нэрэмжит ШУТИС-ийн “Эрдэмийн XVIII чуулган”-ны шилдэг бүтээлийн уралдаанд “БАЯЖУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН” Сэдэвт бүтээл “ГУТГААР БАЙР” эзэлсэн. 2018 он
- “**Монголын инновацийн 7 хоног-2018**” арга хэмжээг 2018 оны 05 дугаар сарын 07-13-ны өдрүүдэд үндэсний хэмжээнд, олон улсын нийтлэг жишгийн дагуу зохион байгуулах ажилд идэвхтэй оролцож



Гарсан үр дүн:

- Өөрсдийн өдөр тутмын амьдралын хэв маягт зохицсон, зөв хооллолтыг хэвшил болгох хүсэл эрмэлзлэлийг олж авсан.
- Оюутнууд бага зардлаар шим тэжээллэг хоол хэрхэн бэлдэхэд суралцсан. Ингэхдээ 10 гаруй нэр төрлийн амт чанартай, хялбар бэлтгэж болох хоолыг хийсэн нь хоолны зуршлыг нэмэгдүүлж, цаашлаад хоол хүнсний хэрэглээний ач холбогдлыг ойлгуулж чадсан.
- Усны ач холбогдлын талаар илүү ойлгож усыг зөв хэрэглэх, хэмнэх сэтгэлгээг олж авсан.
- Оюутнууд өөрсдийн биеийн жингийн индексийг тодорхойлж сурсанаар биеийн жинг хянах, түүнд тохирсон зөв зохистой хоол хүнсийг хэрэглэх тухай мэдлэг олж авсан.

Зөв зохистой хооллох хүсэл тэмүүллийг олж, ирээдүйд өөрсдийнх нь болон гэр бүлийнх нь өдөр тутмын амьдралд зөв хэвшил бий болж үлдэнэ.

Холбоо барих: Клубийн ахлагч: Т.Энхзул Утас: 88139653

Клубийн зөвлөх багш С.Сэржмядаг Утас: 99000340

